**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 24 өдөр Дугаар А/57 Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 1, 2, 3 дугаар багт байрлах 3 нэгж талбарын 2702 $м^2$ газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Цэрэндүг Тунгалаггоо, Галиндэв Саруулбуян, Дагмид Батмөнх нарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2018 оны А/122 дугаар захирамж, 2023 оны А/279 дүгээр захирамж, 2020 оны А/76 дугаар захирамж, газар эзэмших эрхийн 000694605, 0000238171, 000029787 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Г.ОДГЭРЭЛ

401100113

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
..01.... дугаар сарын ..24... –ний өдрийн А/57
дугаар захирамжийн хавсралт

**ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХ ШИНЭЭР ҮҮССЭН ИРГЭДИЙН НЭРС**

| Д/д | Газар эзэмшигч иргэн аж ахуйн нэгжийн нэр | Регистрийн дугаар | Шилжүүлэгч иргэн, аж ахуй нэгж, байгууллагын газрын хэмжээ /м2/ | Шилжүүлэн авагчийн нэр | Регистрийн дугаар | Шилжүүлэн авагч иргэн, аж ахуй нэгж, байгууллагын газрын хэмжээ /м2/ | Хугацаа /жил/ | Газрын байршил | Зориулалт | Нэгж талбарын дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цэрэндүг Гантулга | ЙР79010715 | 1056 | Цэрэндүг Тунгалаггоо | ЙР73121309 | 1056 | 39 | Вангийн овоо Өл 19-25 | Гэр бүлийн хэрэгцээ | 6209000431 |
| 2 | Ишгэн Ундрахбаяр | ЙЛ81031100 | 1000 | Галиндэв Саруулбуян | ЙР90010709 | 1000 | 14 | Эрдэнэзуугийн гудамж 1-238б | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв, цогцолбор | 6209008010 |
| 3 | Мангал Пүрэвбаатар | ЙМ76112318 | 646 | Дагмид Батмөнх | АС94051212 | 646 | 39 | Арцат 9-1 | Гэр бүлийн хэрэгцээ | 6209001662 |
| | | | **2702** | | | **2702** | | | | |

----- ЗДТГ -----